



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 14 нэрийн, нийт 92,912,858.00 (ерэн хоёр сая есөн зуун арван хоёр мянга найман зуун тавин найм) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 24,944,284.13 (хорин дөрвөн сая есөн зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун наян дөрвөн төгрөг арван гурван мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001601

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
30 дугаар тогтоолын хавсралт

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГҮЙ,
АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		Цаашид ашиглах хугацаа /жилээр/	
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ		
1	Суудлын автомашин Санта- Пи, 72-27 УНУ	2013-08-02	57,432,850.00	1	57,432,850.00	19,144,283.33	1	19,144,283.33	2
2	Цаг бүртгэлийн төрөөхөмж	2018-04-30	650,000.00	1	650,000.00	130,000.00	1	130,000.00	1
3	Нууцын сейф	2012-01-01	1,165,000.00	1	1,165,000.00	1,165,000.00	1	1,165,000.00	10
4	Нууцын сейф	2012-01-01	1,265,000.00	1	1,265,000.00	1,265,000.00	1	1,265,000.00	10
5	Утгагчийн ширээ /Төрийн сан өрөө/	2014-01-02	670,000.00	3	2,010,000.00	67,000.00	3	201,000.00	3
6	Файлын хэвтээ шкаф /дэд сайд, тнбд-ын туслах	2014-01-02	600,000.00	3	1,800,000.00	60,000.00	3	180,000.00	3
7	Файлын шүүгээ хэвтээ /Дарга нарын өрөө/	2014-01-02	600,000.00	11	6,600,000.00	60,000.00	11	660,000.00	3
8	Файлын шкаф /дэд сайд, тнбд-ын туслахын	2014-01-02	1,100,000.00	3	3,300,000.00	110,000.00	3	330,000.00	3
9	Хувцасны шүүгээ Дэд сайдын өрөө	2014-01-02	1,500,000.00	1	1,500,000.00	150,000.00	1	150,000.00	3
10	Хувцасны шкаф ТНБД-ын туслахын өрөө	2014-01-02	1,080,000.00	1	1,080,000.00	108,000.00	1	108,000.00	3
11	Буйдан Дэд сайдын өрөө уулзалтын	2014-01-02	1,000,000.00	1	1,000,000.00	100,000.00	1	100,000.00	3
12	Буйдан ТНБД-ын уулзалтын өрөө	2014-01-02	1,000,000.00	1	1,000,000.00	100,000.00	1	100,000.00	3
13	Уулзалтын ширээ сандлын ком	2014-01-02	708,334.00	12	8,500,008.00	70,833.40	12	850,000.80	3

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа /жилээр/
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)	
14	Тумбочка мэргэжилтэн нар	2014-01-02	110,000.00	51	5,610,000.00	11,000.00	51	561,000.00	3
	НИЙТ ДҮН			91	92,912,858.00 (ерэн хоёр сая есөн зуун арван хоёр мянга найман зуун тавин найм)		91	24,944,284.13 (хорин дөрвөн сая есөн зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун наян дөрвөн төгрөг арван гурван мөнгө)	